



“БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН САНХҮҮЖИЛТИЙН САНААЧИЛГА” ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН ХУРААНГҮЙ

А. МОНГОЛЫН БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН ОНЦЛОГ, ТӨЛӨВ БАЙДАЛ

1. “Биологийн олон янз байдал” гэдэг нэр томъёоны дор зөвхөн амьтан, ургамлын төрөл зүйлийн олон янз байдал гэж ойлгох ойлголт түгээмэл байна.

“Биологийн олон янз байдал” (БОЯБ) гэдэг нэр томъёо Монгол улс БОЯБ -ын конвенцид нэгдэн орсон цаг үеэс л (1992 он) нутагшиж эхэлсэн бөгөөд аливаа бодлого, төлөвлөлтийн баримт бичигт БОЯБ гэсэн шууд нэрээрээ биш байгаль орчны ерөнхий асуудлын хүрээнд байгаль орчныг хамгаалах¹, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, тусгай хамгаалалттай газар нутаг, ховордсон амьтан, ургамлын хамгаалах хэлбэрээр тусгалаа олж байв. БОЯБ гэдэг нь дэлхий дээрх амьд бие организмын олон янз байдал, тухайлбал хуурай газар, далай тэнгис, усан орчны экосистем, экосистемийн бүрэлдэхүүн хэсэг болох амьтан, ургамал зэрэг амьд биет болон тэдгээрийн генетикийн олон янз байдлыг багтаасан нийлмэл ойлголт, бүрэн төгс ажиллагаа бүхий амьдралын цогц тогтолцоо юм. Энэ утгаараа БОЯБ-ын Үндэсний хөтөлбөр нь байгалийн баялгийг хамгаалах, зохистой ашиглах, хомсдолд орсон нөөцийг нөхөн сэргээх “шүхэр” хөтөлбөр юм.

2. Монгол орон нь Сибирийн тайгаас Төв Азийн хуурай хээр, цөлийн бүст шилжих шилжилтийн заагт оршдог учраас БОЯБ-ын хувьд харьцангуй баялаг болохын сацуу зүйлийн өвөрмөц байдлаараа бүс нутгийн хэмжээнд онцлог бөгөөд чухал ач холбогдолтой.

Монгол Улсын газар нутаг дээр бүрэлдэн бий болсон БОЯБ нь 20-р зууны дунд хүртэл онгон төрхөөрөө байгаа байгалийн экосистемийн нэгдмэл үндсэн шинжийг агуулж байсан бөгөөд бэлчээрийн мал аж ахуй нь жилийн 4 улирал, газар нутгийн онцлог байдалдаа нийцсэн, хүний амь зуулгын хэрэгсэл, хагас байгалийн экосистем байв. Энэ бол газарзүйн тухайн орчин, уур амьсгалын хувьсал, өөрчлөлтийн тухайн нөхцөлд БОЯБ бүрэлдэн тогтворжих боломжийн дээд цэг байсан гэж үзэж болох юм.

3. 20-р зууны 2-р хагасаас Монгол улсын нутаг дээр зэрлэг амьтдын идээшил нутгийн хумигдал, тасархайтал, амьдрах орчны доройтол гэх мэт аюул, дарамтууд шинээр эрч хүчээ авч байна

Монгол орны нутаг дэвгэрээс 20-р зууны сүүлийн хагаст цөөвөр чоно (1968 он), Тахь адуу (1950иад он), Соргог бөхөн (1950иад он) устаж үгүй болсон нь үүний бодит жишээ юм.

4. Монгол орны нутаг дэвсгэрийн дийлэнх нь (98.4%)² байгалийн буюу байгалийн төрхөөрөө байгаа экосистем зонхилж, тэдгээрийн гол тодорхойлогч зүйл болох зарим зэрлэг амьтан, ургамлын тоо, толгойн нягтшрал нь хэвийн хэмжээнд байгаа нь БОЯБ-ыг хамгаалахад зарцуулах ирээдүйн зардлыг хэмнэх ихээхэн боломж байна.

¹ “Байгаль орчныг хамгаалах” гэдэгт байгаль орчныг бохирдохоос урьдчилан сэргийлэх, байгалийн баялгийг жам ёсоороо нөхөн сэргээх боломжийг нь алдагдуулахгүйгээр, байгалийн даацад нь тохируулан зохистой ашиглах, нөхөн сэргээх, тэдгээрт хяналт тавих ажиллагаа хамаарна”, Байгаль хамгаалах тухай хууль, 3.2.7

² Газрын нэгдмэл сангийн 2014 оны улсын нэгдсэн тайлан, 2015, Газрын харилцаа, геодези зураг зүйн газар



Гэвч байгалийн нөөцөөс хамааралтай (**мал аж ахуй**) болон байгалийн нөөцөд түшиглэсэн (**эрдэс баялаг**) эдийн засгийн голлох салбарын нөлөөллийг авч үзэхэд байгалийн нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах, нөхөн сэргээхэд гаргаж буй хүчин чармайлт нь жингийн хувьд маш бага байгаа нь **ирээдүйд БОЯБ-г улам ихээр доройтуулах, улмаар хамгаалалд зарцуулагдах зардлыг нэмэгдүүлэхээс бус бууруулах боломжийг багасгаж** байна.

5. Бүтэц, зохион байгуулалт, менежментийн өнөөгийн хэв загвар нь БОЯБ-д тулгарч буй дарамтыг нөхцөлдүүлж байна.

БОЯБ-д дам болон шууд байдлаар хамгийн их сөрөг нөлөө үзүүлж буй хүчин зүйл нь удирдлага, зохион байгуулалт, менежментийн сул тал бөгөөд энэ нь Монгол улсын хувьд БОЯБ-ыг тогтворжуулах явдалд шилдэг арга барилд тулгуурласан зөв бодлого, оновчтой үйл ажиллагаа нь голлох үүрэгтэй байгааг харуулж байна. Ялангуяа Монгол улсын эдийн засаг, санхүүгийн хүндрэлтэй өнөөгийн нөхцөлд БОЯБ-ыг хамгаалах, тогтворжуулах **нэг гарц нь:**

- зөв бодлого, эрчимтэй үйл ажиллагаа;
- бүтэц зохион байгуулалт, менежментийн оновчтой хувилбар;
- иргэдийн үүсгэл санаачилгад үндэслэсэн олон нийтийн оролцоо;
- ашгийн сонирхол, нийгмийн хариуцлагын тэнцвэрт тулгуурласан хувийн хэвшлийн үйл ажиллагаа

голлох үүрэгтэй байхаар байна.

Б. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫН САНХҮҮЖИЛТИЙН ОДООГИЙН БАЙДАЛ ИРЭЭДҮЙН ХАНДЛАГА

1. 2008-2015 оны БОЯБ-ын нийт зарцуулалт нь 136,1 сая ам доллар³ бөгөөд холбогдох хугацаанд тухайн жилийн улсын нэгдсэн төсвийн нийт зардалд 0.32%-0,77%, ДНБ-ний 0.13%-0.30%-ийг тус тус эзэлж байна.

Энэ хугацаанд жил бүрийн зарцуулалт нь дундажаар 12,9-21,6 сая ам доллар байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулсан өөрчлөлтийг авч үзэхэд 2011 онд өсөлт хамгийн бага буюу 3,3%, 2010 онд хамгийн өндөр буюу 21,1% байна. ТХГН-ын Хамгаалалтын захиргаа, яамны болон орон нутгийн ойжуулалтын зардал нь шууд зардлын томоохон хувийг эзэлж буйг эс тооцвол улсын төсвийн санхүүжилтээр хийсэн шууд зарцуулалт маш бага байна.

2. Нийт санхүүжилтийн 50,1%-ийг улсын болон орон нутгийн төсвөөс, харин 49,9%-ийг Олон улсын байгууллагуудын санхүүжилт эзэлж байгаа нь донороос ихээхэн хараат байгааг харуулж байна

Улсын төсвөөс хийгдсэн санхүүжилтийн 67.8%-ийг БОАЖЯ болон түүний харъяа 6 нэгжид хамаарах зардал, 5.8%-ийг БШУСЯ болон түүний харъяа 7 байгууллагад хамаарах зардал, 17.2%-ийг ХХААЯ болон түүний харъяа нэг байгууллагад хамаарах зардал, Үндэсний статистикийн газар 0.2%, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар 1,5%, орон нутгийн зарцуулалт⁴ 7.4%-ийг тус тус эзэлж байна. Олон улсын байгууллагуудын хэрэгжүүлсэн төслийн зарцуулалтын 35.5%-ийг SDC, 28.8%-ийг UNDP, 13.7%-ийг WWF, 7.9%-ийг FAO эзэлж байгаа бөгөөд ADB, TNC, WCS зэрэг байгууллагуудын төслийн зарцуулалт нь тус бүр 3.9%-6.1%-ийг эзэлж байна. SDC, GIZ, UNDP-ийн

³ Жил бүрийн зарцуулалтыг тухайн жилийн 12 сарын 31-нээрх Монгол банкны зарласан ханшаар хөрвүүлсэн.

⁴ Аймаг, сумдын нийт зарцуулалтыг тодорхойлох боломжгүй тул Байгалийн нөөц ашигласны төлбөрөөс орон нутгийн төсөвт төвлөрүүлж, хуулийн дагуу зарцуулсан хувийг авч үзэв.



төслүүдийн зарцуулалт нь тус бүр 22%-27%-ийг, бусад байгууллагуудынх тус бүр 10,5%-иас багыг тус тус эзэлж байна.

3. Ирэх 4 жилд БОЯБ-ын санхүүжилт, ялангуяа улсын төсвөөс хийгдэх шууд хөрөнгө оруулалтын санхүүжилт өсөх магадлал тун бага байна.

В. БОЯБ-ЫН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ЗАРДАЛ, ТҮҮНИЙ ХЭРЭГЦЭЭ

БОЯБ-ын үндэсний хөтөлбөрийг 2017-2021 онд хэрэгжүүлэхэд нийт 123,9 сая ам доллар⁵ шаардлагатай тооцоо урьдчилсан байдлаар гарсан. БОЯБ-ын хөтөлбөрийн зорилтуудад хамаарах 2008-2015 оны зарцуулалтад үндэслэн улсын төсвөөс хийгдэх санхүүжилтийг тодорхойлоход энэхүү шаардагдах нийт зардлын 40,4 сая ам доллар буюу 32,6%-ийг улсын төсвөөс хийх боломжтой байна. Донор болон олон улсын байгууллагуудын хэрэгжүүлж буй болон төлөвлөгдсөн төслийн төсвийн 2017-2021 мэдээллийг хамаарлын хувиар тооцон авч үзэхэд 7 байгууллагын 26 төслийн хүрээнд 38,4 сая ам долларыг тус хөтөлбөрийн хүрээнд зарцуулагдах боломжтой, ингэснээр хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтэд 45,2 сая ам.доллар буюу шаардагдах нийт санхүүжилтийн 36,4%-ийн эх үүсвэр дутагдах тооцоо гарч байна. Санхүүжилтийн хэрэгцээ 2017 онд хамгийн бага буюу 1.4 сая ам доллар, 2018 оноос эхлэн огцом нэмэгдэж жилдээ 9,8 сая-13,4 сая ам доллар байна. Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлэн бэхжүүлэх, Ойн менежментийг сайжруулсан монгол орны ойн ойрхог чанарыг 9 хувьд хүргэж, түүний доторх биологийн олон янз байдлыг хамгаалах, Хөрс усыг химийн бохирдлоос хамгаалах зэрэг 3 зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд санхүүжилт хамгийн их дутагдалтай буюу хөтөлбөрийн хэрэгжилтэд дутагдаж буй нийт санхүүжилтийн 64,1% буюу 3 зорилго тус бүр 20,2%-23%-ийг эзэлж байна.

Г. САНХҮҮЖИЛТИЙН ХЭРЭГЦЭЭГ НӨХӨХ ШИЙДЛҮҮД

1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулснаар байгаль хамгаалах, нөхөн сэргээлтэнд зарцуулах хөрөнгийн хэмжээг жилд дунджаар 15 – 16 тэрбум төгрөгт хүргэх боломжтой . Тухайлбал: Ус рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогыг⁶ усны сан бүхий газрыг тэмдэгжүүлэх, хамгаалахад хуулиар тогтоосон доод хэмжээнд зарцуулбал санхүүжилтийн дутагдал хамгийн өндөр буй 3 зорилгын нэг болох “Хөрс усыг химийн бохирдлоос хамгаалах”-д шаардагдах үйл ажиллагааны санхүүжилтийг бүрэн нөхөх боломжтой, ингэснээр нийт санхүүжилтийн дутагдал 21%-иар буурах боломж харагдаж байна.

“... 2013 онд аймгийн төсвийн байгалийн нөөц ашигласны төлбөрийн нийт орлогыг 3358736,7 мянган төгрөгөөр, үүнээс байгаль орчныг хамгаалах, байгалийн баялагийн нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг 722800,0 мянган төгрөгөөр төлөвлөсөн нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулиар тогтоосон хувь хэмжээнээс даруй 2,0 дахин бага байна. . Гүйцэтгэлээр байгалийн нөөц ашигласны орлого болох 3132056,4 мянган төгрөгөөс дээрх

⁵ Монгол банкны 2016 оны 12 сарын 31-ний ханшаар хөрвүүлсэн.

⁶ Эх сурвалж: БОАЖЯ-наас Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 2014 оны хэрэгжилтийн талаарх статистик мэдээгээр Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогод нийт 30,6 тэрбум төгрөг төвлөрсөн, хуулийн дагуу тогтоосон хамгийн бага хувь хэмжээгээр зарцуулах дүн нь 16,8 тэрбум төгрөг байх тооцоо гаргасан.



арга хэмжээнд 1379649,5 мянган төгрөг зарцуулах ёстой атал 668700,0 мянган төгрөг зарцуулж тогтоосон хувь, хэмжээнээс мөн л 2,1 дахин бага хөрөнгө зарцуулсан байна. 2014 онд байгаль орчныг хамгаалах, байгалийн баялагийн нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг тогтоосон хувь хэмжээнээс 2,2 дахин багаар төлөвлөж, санхүүжүүлэхдээ 3,8 дахин багаар / байгалийн нөөц ашигласны татварын орлогын дөнгөж 26,4 хувьтай тэнцэх / гүйцэтгэжээ.” Сэлэнгэ аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар болон байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний үр дүнд (2013 – 2014) хийсэн Аудитын тайлангаас

2. Бэлчээрийн төлбөрийг эргэн сэргээснээр хамгийн багадаа 5.6 тэрбум төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх боломжтой бөгөөд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу үүний 30 хувийг зөвхөн бэлчээрийн менежментэнд ашиглана гэж үзэхэд 1.7 тэрбум төгрөгийг жил бүр зарцуулах боломтой.

“Монгол мал” хөтөлбөрийн нэг тэргүүлэх чиглэлийг “үүр амьсгал, байгаль, экологийн өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадавхитай мал аж ахуйг хөгжүүлэх”-ээр тогтсон бөгөөд энэ тэргүүлэх чиглэлийн хүрээнд “малын тоо, төрлийг бэлчээрийн даацтай уялдуулах, бэлчээрийн даац хэтэрсэн нутагт байлгах малын тооны дээд хязгаарыг тогтоож, түүнээс давуулахгүй байлгах эдийн засгийн хөшүүргүүдийг бий болгох (3.4.1.3), малчин болон мал бүхий иргэдээс малынх нь төрөл, бүс нутгийн онцлогийг харгалзан бэлчээр ашигласны төлбөр авах эрх зүйн орчныг бүрдүүлж, түүний тодорхой хэсгийг бэлчээр хамгаалах, сайжруулахад ашиглах (3.4.1.4)” зорилтыг дэвшүүлсэн байна. Уян хатан татварын бодлого нь төрөөс авч хэрэгжүүлдэг эдийн засгийн сонгодог механизм бөгөөд татварын зөв бодлогыг оновчтой хэрэгжүүлснээр тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тусгагдсан МАА-н талаар баримтлах бодлогын зорилтод хүрэх бүрэн боломжтой.

3. Хувийн хэвшилд тулгуурласан “Монголын Байгаль Хамгаалах Итгэлцлийн Сан”-г байгуулах замаар гадаад, дотоодын хувийн хөрөнгө оруулалтыг татах боломжтой.

Монголын анхны “Монголын Байгаль Орчны Итгэлцлийн Сан”-г байгуулж байсан 1997 оноос хойш Монгол улсын эдийн засаг, хууль эрхзүй, банк санхүүгийн салбарт ихээхэн өөрчлөлтүүд орсон. Жишээлбэл 1997 онд нэг хүнд оногдох ДНБ 329.78 ам.доллар байсан бол 2015 онд 4000 гаруй ам.доллар болж өссөн, ДНБ-ны 80 орчим хувийг хувийн хэвшил бүрдүүлж байгаа зэрэг болно. Мөн хувийн хэвшлээс нийгмийн хариуцлагын чиглэлээр оруулсан хөрөнгө оруулалт нь ч мэдэгдэхүйц өссөн байна. МХАҮТ-аас “Entrepreneur” шалгаруулахад компаниудын нийгмийн хариуцлагыг нэг шалгуур үзүүлэлт болгодог бөгөөд 2015 онд 15 компаниас авсан мэдээгээр нийт 93 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь анхны БОИС-д хувийн хэвшлийн оролцоо байхгүй байсан бол одоо хувийн хэвшил нь БОИС байгуулахад гол оролцогчийн хэмжээнд хүрсэнийг илтгэх үзүүлэлт юм.

4. Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн зарим хөрөнгө оруулалт, урсгал зардлыг “Бизнес тулгуурласан санхүүжилтийн шийдэл”-ээр санхүүжүүлэх боломжтой

Энэхүү санхүүжилтийн шийдэл нь тухайн газрын байгалийн баялагт тулгуурласан үр ашигтай бизнест хөрөнгө оруулалт хийх замаар тогтвортой санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхэд оршино. Энэ аргыг үр дүнтэй хэрэгжүүлж буй гадаад, дотоодын олон түршлага байдаг бөгөөд үүний нэг жишээгээр Хустайн байгалийн цогцолборт газрыг дурьдаж болох юм. Тахь нутагшуулах төсөл хэрэгжүүлэхээр Хустайн байгалийн цогцолборт газрыг байгуулсан бөгөөд төслийн хүрээнд аялал, жуулчлал хөгжүүлэх дэд бүтцийг бий болгосноор аялал, жуулчлалаас олсон орлогоороо үйл ажиллагаагаа санхүүжүүлж байна.